



ҮНДЭСНИЙ  
СТАТИСТИКИЙН  
ХОРОО



МОНГОЛ УЛСЫН

# ЭКСПОРТЛОГЧ

АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН  
НӨХЦӨЛ БАЙДАЛ

СЭДЭВЧИЛСЭН СУДАЛГАА

2022 он



ҮНДЭСНИЙ  
СТАТИСТИКИЙН  
ХОРОО



МОНГОЛ УЛСЫН

# ЭКСПОРТЛОГЧ

АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН  
НӨХЦӨЛ БАЙДАЛ

СЭДЭВЧИЛСЭН СУДАЛГАА

2022 он





## ГОЛ ҮГ



Бизнесийн орчныг тогтмол судлан гадаад дотоод орчны нөлөөлөгч хүчин зүйлс, үүсэж буй хүндрэл, сайжруулах боломжийг тодорхойлж, бодит судалгаа мэдээлэлд үндэслэсэн цаг үеэ олсон бодит дэмжлэг, арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь бизнесийг дэмжин хөгжүүлэхэд хамгийн чухал билээ. Иймд МҮХАҮТ нь 2000 оноос эхлэн бизнесийн орчинтой холбоотой судалгаануудыг тогтмол явуулж, судалгааны дүнд гарсан санал зөвлөмжүүдийг бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нарт хүргэж ирсэн.

МҮХАҮТ ба Үндэсний статистикийн хороо хамтран Монгол Улсын экспортлогч аж ахуйн нэгжүүдийн бодит тоон мэдээлэлд үндэслэн энэхүү судалгааны

үр дүнг боловсруулан тайланг та бүхэнд толилуулж байна.

Монгол Улсын экспортын салбар 2021 онд 9.2 тэрбум америк долларт хүрч, үнийн дүнгээр ДНБ-ий 60.5 хувьтай тэнцэж байна. Үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн 4.2 хувь нь энэ салбарт ажиллаж байгаа хэдийн ч түүхий эд бэлтгэн нийлүүлэгч, ханган нийлүүлэлтийн сүлжээний оролцогч талуудыг тооцвол илүү өргөн салбарыг хамарсан манай улсын эдийн засгийн нөлөө бүхий салбар болжээ.

Тэр дундаа уул уурхайн бус экспортын салбарт 1800 орчим аж ахуйн нэгжүүд заримдаа болон тогтмол экспорт хийж, нийт экспортын дүнгийн 6 орчим хувийг бүрдүүлж байгаа боловч эдгээрийн түүхий эд, ханган нийлүүлэлтийн сүлжээнд 300 гаруй мянган хүн ажиллаж, өрхийн орлогыг шууд нэмэгдүүлэх эдийн засаг нийгмийн онцгой ач холбогдолтой салбар болсон байна. Энэхүү судалгааны дүнгээр экспортлогч аж ахуйн нэгжүүдийн 90 орчим хувь нь экспортын хэрэгцээтэй санхүүжилтээ өөрийн хөрөнгөөр бүрдүүлж байгаа ба мөн дотоодын банк, хувь хүмүүсээс зээлийн эх үүсвэрийг бүрдүүлж байна гэж гарсан. Иймд экспорт хийх үйл ажиллагаа зардал өндөртэй, шаардлагатай санхүүжилт олох боломж нөөц хомс учир экспортлогч аж ахуйн нэгжүүд хангалттай өргөжиж чадахгүй, харин тэдний дутагдаж буй орон зайд сул мөнгөтэй ченжүүд ноёрхож байна.

Түүнчлэн нийт экспортын бараа бүтээгдэхүүний ойролцоогоор 95 хувь нь түүхий эд хэлбэрээр гарч боловсруулалт нь хилийн цаана хийгдэж байгаа нь эдийн засгийн үр ашиг багатай, өрхийн орлогод хангалттай эерэг нөлөө үзүүлж чадахгүй байна. Монгол Улсын засгийн газрын шинэ сэргэлтийн бодлогод “Нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ” гэж заасан боловч бодит нөхцөл байдалд удаашралтай байна. Иймээс экспортлогч аж ахуйн нэгжүүдийн нөхцөл байдлыг бодитой үнэлэн дүгнэж, үр дүнтэй шийдэл бодлого боловсруулах нь илүү чухал болоод байна.



Энэхүү судалгааны дүнг Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, төрийн яам агентлагуудад МҮХАҮТ-ын зүгээс хүргэх бөгөөд цаашид бизнесийн орчныг сайжруулах чиглэлд төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, экспортын санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох, экспортын салбарыг дэмжин хөгжүүлэхэд анхаарч, манлайлан ажиллах болно.



МҮХАҮТ-ын дарга Т.Дүүрэн



## АГУУЛГА

ГОЛ ҮГ .....	3
УДИРТГАЛ .....	9
Судалгааны зорилго, арга зүй.....	11
<b>I. Монгол Улсын экспортын өнөөгийн нөхцөл байдал.....</b>	<b>12</b>
1.1. Экспортын бүтцийн өөрчлөлт .....	12
1.2. Экспортын түнш орнууд .....	15
<b>II. Монгол Улсын экспортлогч аж ахуйн нэгжүүдийн нөхцөл байдал.....</b>	<b>18</b>
2.1. Монгол Улсын экспортлогч аж ахуйн нэгжийн ерөнхий үзүүлэлт .....	18
2.2. Санхүүгийн нөхцөл байдал.....	22
2.3. Хүний нөөц.....	28
2.4. Инновац, судалгаа хөгжүүлэлт, технологийн хэрэглээ.....	33
2.5. Бизнесийн орчны нөхцөл байдал.....	38
Экспортлогч аж ахуйн нэгжүүдийн нөхцөл байдлын дүгнэлт .....	42
ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ .....	44
Ашигласан материал.....	46

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААН	Аж ахуйн нэгж
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БТКУС	Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЕХ	Европын холбоо
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэр
ЗГ	Засгийн газар
МАА	Мал аж ахуй
МУИС	Монгол Улсын Их Сургууль
МҮХАҮТ	Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОУ	Олон улс
ОХУ	Оросын Холбооны Улс
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХЗХ	Хадгаламж зээлийн хоршоо
ISO	International Organization for Standardization
UNCTAD	United Nations Conference on Trade and Development



## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Монгол Улсын нийт экспорт, сая америк.доллороор, 1995-2021 он.....	12
Зураг 2. Нийт экспортын бүтэц (үнийн дүнгээр, уул уурхайн болон уул уурхайн бус бүтээгдэхүүний төрлөөр), 1995-2021 он .....	12
Зураг 3. Уул уурхайн бус бараа бүтээгдэхүүний экспорт, өсөлт, 1995-2021 .....	13
Зураг 4. Уул уурхайн бус бараа бүтээгдэхүүний экспорт, барааны бүлэг, мян.америк.доллороор, 2002-2021 .....	13
Зураг 5. Уул уурхайн бараа, бүтээгдэхүүний экспорт, барааны бүлэг, мян.америк.доллороор, 2002-2021 он .....	15
Зураг 6. Монгол Улсын экспортын түнш орнууд, экспортоор гаргасан гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний нэр төрлийн тоогоор, 2021 он .....	16
Зураг 7. Зарим гол нэрийн бараа, бүтээгдэхүүний нэгжийн үнэ ба экспортолсон улсын тооны хамаарал.....	17
Зураг 8. Экспортод бүтээгдэхүүн үйлчилгээ гаргасан аж ахуйн нэгжийн тоо, байршлаар.....	18
Зураг 9. Экспортын бүтээгдэхүүн үйлчилгээ гаргасан аж ахуйн нэгжийн тоо, салбараар .....	19
Зураг 10. Экспортлогч аж ахуйн нэгж, борлуулалтын орлогын түвшингээр, хувиар, 2020 он .....	19
Зураг 11. Экспортлогч аж ахуйн нэгж, ажиллагчдын тооны бүлгээр, хувиар, 2020 он .....	20
Зураг 12. Экспортлогч аж ахуйн нэгж, хөрөнгө оруулалтын хэлбэрээр, 2020 он .....	20
Зураг 13. Гадаадын хөрөнгө оруулалттай экспортлогч аж ахуйн нэгж, эдийн засгийн салбараар, 2020 он .....	20
Зураг 14. Экспортлогч аж ахуйн нэгжийн санхүүжилтийн байдал, санхүүжилтийн эх үүсвэрээр, 2020 он.....	22
Зураг 15. Экспортлогч аж ахуйн нэгжийн санхүүжилтийн байдал, санхүүжилтийн эх үүсвэрээр, салбараар, 2020 он .....	23
Зураг 16. Экспортлогч аж ахуйн нэгж, санхүүжилтийн эх үүсвэр, экспорт хийдэг давтамжаар, хувиар, 2020 он .....	24
Зураг 17. Экспортлогч аж ахуйн нэгж, санхүүжилтийн эх үүсвэр, борлуулалтын орлогын бүлгээр, хувиар, 2020 он.....	24
Зураг 18. Экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээ тогтмол гаргадаг аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн байдал, хувиар /2021 оны эхний 9 сарыг 2020 оны эхний 9 сартай харьцуулсан .....	25
Зураг 19. Мөнгөн хөрөнгийн нөөцийн хүрэлцээтэй хугацаа, хувиар, 2020 он .....	26
Зураг 20. Зээлтэй аж ахуйн нэгж, экспортлогч эсэх, хувиар, 2020 он.....	26
Зураг 21. Зээлтэй аж ахуйн нэгж, зээлийн эх үүсвэрээр, хувиар, 2020 он .....	27



Зураг 22. Аж ахуйн нэгжийн ажиллагчдын тоо, ажиллагчдын тооны бүлгээр, хувиар, 2020 он .....	28
Зураг 23. Экспортлогч аж ахуйн нэгжийн ажиллагчдын тоо, экспорт хийдэг давтамжаар, хувиар, 2020 он .....	29
Зураг 24. Хүний нөөцийн дутагдалтай аж ахуйн нэгж, хувиар, 2020 он .....	29
Зураг 25. Хүний нөөцийн дутагдалтай аж ахуйн нэгж, салбараар, хувиар, 2020 он....	30
Зураг 26. Хүний нөөцийн дутагдалтай аж ахуйн нэгж, шаардлагатай ажилтнаа олж чадахгүй байгаа шалтгаанаар, хувиар, 2020 он.....	31
Зураг 27. Хүний нөөцийн дутагдалтай экспортлогч аж ахуйн нэгж, шаардлагатай ажилтнаа олж чадахгүй байгаа шалтгаанаар, экспорт хийдэг давтамжаар, хувиар, 2020 он .....	31
Зураг 28. Үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгж, өөрийн нөөцөөр ажлын байраа цаашид хадгалах боломжтой хугацаагаар, хувиар, 2020 он .....	32
Зураг 29. 2018-2021 онуудад шинээр эсвэл мэдэгдэхүйц сайжруулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний инновац нэвтрүүлсэн үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгж, хувиар .....	33
Зураг 30. 2018-2021 онуудад инновацын үйл ажиллагааг хэрэгжүүлсэн үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгж, хувиар.....	34
Зураг 31. Инновацын үйл ажиллагаа хийгдэж байгаа аж ахуйн нэгж, хувиар, 2020 он .....	34
Зураг 32. 2018-2021 онуудад бизнесийн үйл явцын инновац нэвтрүүлсэн аж ахуйн нэгж, хувиар.....	35
Зураг 33. 2018-2021 онуудад судалгаа хөгжүүлэлтийн ажил хийсэн аж ахуйн нэгж, хувиар .....	36
Зураг 34 . Судалгаа хөгжүүлэлтийн ажил хийсэн аж ахуйн нэгж, судалгааны төрлөөр, хувиар, 2020 он .....	36
Зураг 35. Аж ахуйн нэгжийн интернэт ашиглалтын зорилго, хувиар, 2020 он.....	37
Зураг 36. Аж ахуйн нэгжийн бизнесийг хөгжүүлэхэд төрийн бодлогын түвшинд нэн тэргүүнд хэрэгжүүлэх арга хэмжээ, хувиар, 2020 он .....	39
Зураг 37. Экспортлогч аж ахуйн нэгжийн бизнесийг хөгжүүлэхэд төрийн бодлогын түвшинд нэн тэргүүнд хэрэгжүүлэх арга хэмжээ, экспорт хийдэг давтамжаар, хувиар, 2020 он .....	40
Зураг 38. Аж ахуйн нэгж, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад төрийн байгууллагаас баримт бичиг, тодорхойлолт шаарддаг байдал, экспорт хийдэг давтамжаар, хувиар, 2020 он .....	40
Зураг 39. Экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргадаг аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа явуулахад төрийн байгууллагад бүрдүүлж өгсөн баримт бичиг, тодорхойлолтын дундаж тоо, 2020 он.....	41





## УДИРТГАЛ

Экспортын салбарын өсөлт нь шууд болон шууд бус байдлаар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, эдийн засгийн бусад салбаруудын урт хугацааны өсөлтийг бий болгодог чухал ач холбогдолтой. Олон улсын судалгаагаар экспортлогч аж ахуйн нэгжүүд бараа бүтээгдэхүүнээ олон улсын зах зээлд борлуулдаг учир шинэ технологийг тогтмол нэвтрүүлэх шаардлагатай байдаг бөгөөд дотоодын зах зээлд өрсөлдөөн бий болгон илүү үр ашигтай, бүтээмж өндөртэй инновацлаг бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх эерэг нөлөөтэй байдаг байна. Түүнчлэн амжилттай экспортлогч аж ахуйн нэгжүүд илүү өргөн зах зээлд бараа бүтээгдэхүүн борлуулж, тэр хэмжээгээр бизнесийн үр ашиг сайжирч, олон улсын стандартын дагуу бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэн, илүү олон ажлын байр бий болгодог. Иймд экспортыг нэмэгдүүлснээр илүү бүтээмжтэй, дэвшилтэт технологид суурилсан, үр ашигтай, хурдацтай хөгжиж буй эдийн засгийг бий болгодог байна<sup>1</sup>. Тухайлбал, 1995-2014 онд Вьетнам улсын экспорт үнийн дүнгээр дэлхийн нийт экспортын 0.11 хувиас 0.94 хувь болж, 9 дахин өссөн ба энэхүү өсөлтийг бий болгоход экспортын бараа бүтээгдэхүүний төрөлжилт нэмэгдсэн, институтийн реформ хийж төрийн үйлчилгээний хүнд суртлыг бууруулан бизнесийн орчныг сайжруулсан гэсэн үндсэн хоёр хүчин зүйл голлон нөлөөлсөн байна.

Харин манай улсын экспортын салбар 1995 онд дэлхийн экспортын 0.01 хувийг, 2014 онд 0.031 хувийг, 2021 онд 0.043 хувийг эзэлж байна. Экспортын үнийн дүнгээр 1995-2021 онд Монгол улсын экспорт 19.5 дахин өсөж, 2021 онд ДНБ-ий 60.5 хувьтай тэнцсэн, нийт аж ахуйн нэгжийн ажиллагчдын 14.3 хувийг ажиллуулдаг манай улсын эдийн засагт чухал нөлөөтэй салбаруудын нэг юм.

Цар тахлын хязгаарлалтын арга хэмжээ дэлхийн бизнес, эдийн засагт сөргөөр нөлөөлж, тодорхойгүй нөхцөл байдал бий болгосон ч 2021 онд дэлхийн худалдааны эргэлт түүхэн дээд хэмжээнд буюу 28.5 их наяд америк долларт хүрсэн нь цар тахлын өмнөх үеэс 13 хувиар өссөн байна. Дэлхийн худалдааны статистик мэдээллээр түүхий эдийн экспортлогч бүс нутгуудад голлон экспортын өсөлт ажиглагдаж байгаа бөгөөд хөгжиж буй орнуудын экспорт 2021 оны 4-р улиралд өмнөх оны мөн үеэс 30 хувиар өссөн байна.<sup>2</sup> Харин манай улсын экспорт 2021 онд өмнөх оноос 22.1 хувиар өсжээ.

Цар тахлын дараа эдийн засаг бизнесээ сэргээх амаргүй үед экспортын хэмжээ, бараа бүтээгдэхүүний төрөлжилтийг нэмэгдүүлэх чиглэлд экспортлогч аж ахуйн нэгжүүдэд бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлснээр эдийн засгийн өсөлтийг дэмжих, улсын төлбөрийн тэнцэлд эерэг нөлөө үзүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх ач холбогдолтой. Иймд бодит статистик тоо мэдээлэлд үндэслэн экспортлогч аж ахуйн нэгжүүдийн нөхцөл байдлыг тодорхойлох, зорилтот арга хэмжээ гарц шийдлийг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх зорилгоор Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Үндэсний Статистикийн Хороотой хамтран 2021 оны аж ахуйн нэгжийн улсын тооллогын үр дүнд үндэслэн энэхүү судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ.

1 Relationship between Exports, Economic Growth and Other Economic Activities in India: Evidence from VAR Model, Mohammad SUBHAN, Majed ALHARTHI, Md Shabbir ALAM, Prabha THOUDAM, Khaliquzzaman KHAN5, 2021

2 Global trade update, UNCTAD, February 2022



Судалгааны ажил нь үндсэн гурван бүлгээс бүрдэнэ. Нэгдүгээр бүлэгт судалгааны ажлын зорилго, арга зүй, ач холбогдлын талаар авч үзлээ. Хоёрдугаар бүлэгт Монгол Улсын экспортын бараа бүтээгдэхүүний бүтцийн өөрчлөлт, түнш орнуудын мэдээллийг ерөнхий байдлаар тоймлон нэгтгэсэн. Гуравдугаар бүлэгт идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа экспортлогч аж ахуйн нэгжүүдийн нөхцөл байдлыг санхүү, хүний нөөц, инновац технологи, судалгаа хөгжүүлэлт болон бизнесийн орчин гэсэн ерөнхий 4 хэсгээр нэгтгэн дүгнэсэн болно.



## СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ

### Зорилго

Энэхүү сэдэвчилсэн судалгааны зорилго нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргадаг аж ахуйн нэгжүүдийн тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийж, экспортлогч аж ахуйн нэгжүүдийн өнөөгийн нөхцөл байдал, аж ахуйн нэгжүүд экспорт хийхэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, шаардлагатай дэмжлэгийг бодитоор тодорхойлон гаргахад оршино.

### Арга зүй, ач холбогдол

Сэдэвчилсэн судалгааг Аж ахуйн нэгжийн 2021 оны улсын тооллогын мэдээлэлд үндэслэн задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, харьцуулалтын аргуудыг ашиглан үр дүнг нэгтгэн боловсруулав. Мөн Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Гаалийн ерөнхий газар, Олон улсын худалдааны төв (ИТС)-ийн статистик тоон мэдээлэлд үндэслэн экспортын бүтцийн өөрчлөлт, худалдааны түнш орнуудын мэдээлэлд шинжилгээ хийсэн болно.

Судалгаагаар экспортоор бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргадаг нийт аж ахуйн нэгжүүдийн нөхцөл байдалд дүгнэлт хийх, эдгээр аж ахуйн нэгжүүдэд тулгарч буй хүндрэл бэрхшээлийг тодорхойлон, үр дүнд үндэслэн хэрэгжихүйц бодит дэмжлэг арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд ач холбогдолтой гэж үзэж байна.

### Ойлголт, тодорхойлолт<sup>3</sup>

Гадаад худалдааны статистикт улс орны материаллаг нөөцийг нэмэгдүүлэн эдийн засгийн нутаг дэвсгэрт орж ирж байгаа бараа бүтээгдэхүүнийг “импорт”, мөн тус нөөцөөс хасагдаж, эдийн засгийн нутаг дэвсгэрээс хилийн чанадад гарч байгаа бараа бүтээгдэхүүнийг “экспорт” гэж тодорхойлон эдгээр бүх төрлийн барааг хамруулан тооцно. Экспорт, импортын нийлбэрээр гадаад худалдааны барааны нийт эргэлтийг тодорхойлно. Гадаад худалдааны тэнцлийг экспортоос импортыг хасаж тооцох ба тэнцэл (-) тэмдэгтэй бол алдагдалтай, (+) тэмдэгтэй бол ашигтай гэж үзнэ.

Энэхүү судалгаанд экспортын бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэж, хилийн чанадад гаргаж буй экспортлогч аж ахуйн нэгжийн мэдээлэлд тооцоо, судалгаа хийв. Нийт экспортод Монголын барааны шууд экспорт, гадаадын барааны реэкспорт багтана. Барааны реэкспортод Монгол Улсын гаалийн нутаг дэвсгэрт урьд нь оруулсан боловч ямар нэг дахин боловсруулалт хийгдээгүй, гаалийн татвар, хураамж болон төлбөргүй, эдийн засгийн хориг хязгаарлалтгүйгээр гадаадад гаргасан барааг оруулна.

Гадаад худалдааны статистикийн мэдээллийг гаргах үндсэн бүртгэл нь гаалийн мэдүүлэг бөгөөд гаалийн бүрдүүлэлт хийсэн эцсийн өдрөөр экспорт, импортыг бүртгэж, статистикийн албан ёсны мэдээнд тусгадаг байна. Гадаад худалдааны статистикийн мэдээллийг Дэлхийн худалдааны байгууллагын “Барааг тодорхойлох кодлох, уялдуулсан систем (БТКУС)”-ийн ангиллын дагуу барааны бүлэг, нэр төрлөөр харуулдаг.


<sup>3</sup> Гадаад худалдаа-2021, Үндэсний статистикийн хороо

# I. МОНГОЛ УЛСЫН ЭКСПОРТЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

## 1.1. Экспортын бүтцийн өөрчлөлт


Монгол Улсын экспортын салбар сүүлийн 26 жилийн хугацаанд хурдацтайгаар өргөжсөн байна. 1995-2021 оны хооронд нийт экспорт жилд дунджаар 14.5 хувиар өсжээ. Үүнд уул уурхайн экспорт жилд дунджаар 17.1 хувиар, уул уурхайн бус бараа, бүтээгдэхүүний экспорт дунджаар 7.2 хувиар тус тус өссөн байна (Зураг 1).

Зураг 1. Монгол Улсын нийт экспорт, сая америк.доллаар, 1995-2021 он



2000 оноос хойш Монгол Улсын экспортын бүтцэд уул уурхайн бараа, бүтээгдэхүүний экспортын өсөлт тогтвортой нэмэгдэн үнийн дүнгээр 2000 онд уул уурхайн бараа бүтээгдэхүүн нийт экспортын 50 орчим хувийг бүрдүүлж байсан бол 2021 онд 92.2 хувь болсон байна. Харин 2000-аад он хүртэл нийт экспортын 50 орчим хувийг эзэлж байсан уул уурхайн бус бараа, бүтээгдэхүүний хувь хэмжээ 2003 оноос тасралтгүй буурах хандлагатай болж, 2021 онд үнийн дүнгээр нийт экспортын 7.6 хувь болжээ (Зураг 2).

Зураг 2. Нийт экспортын бүтэц (үнийн дүнгээр, уул уурхайн болон уул уурхайн бус бүтээгдэхүүний төрлөөр), 1995-2021 он






## Уул уурхайн бус бараа, бүтээгдэхүүний экспорт


1995-2021 оны статистик мэдээг авч үзвэл Монгол Улсын уул уурхайн бус бараа, бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувь хэмжээ буурсан боловч үнийн дүнгээр жилд дунджаар 7.2 хувиар өсөж, 2021 онд 705.8 сая америк долларт хүрсэн нь 2002 оноос 3.1 дахин өссөн дүнтэй байна (Зураг 3).

Зураг 3. Уул уурхайн бус бараа бүтээгдэхүүний экспорт, өсөлт, 1995-2021



Үнийн дүнгээр уул уурхайн бус бараа, бүтээгдэхүүний экспортын 50 орчим хувийг нэхмэл болон нэхмэл бүтээгдэхүүн бүлгийн бараа ялангуяа ноос, ноолуур эзэлсэн хэвээр байна (Зураг 4).

Зураг 4. Уул уурхайн бус бараа бүтээгдэхүүний экспорт, барааны бүлэг, мян.америк. доллароор, 2002-2021



2021 онд уул уурхайн бус бараа, бүтээгдэхүүний экспортын 52.5 хувийг дангаар бүрдүүлсэн нэхмэл болон нэхмэл бүтээгдэхүүн бүлгийн бараа нь 2002 оноос жилд дунджаар 6 хувиар буюу нийт 225.5 сая америк доллароор өссөн байна. 2021 онд нэхмэл болон нэхмэл бүтээгдэхүүн бүлгийн бараа нь өмнөх оноос 91.2 сая америк доллароор буюу 32.6 хувиар өсөж, хамгийн өндөр өсөлттэй жил болжээ.



Уул уурхайн бус экспортын дараагийн нэг голлох бүтээгдэхүүн нь үндсэн төмөрлөгийн гаралтай бүтээгдэхүүн бөгөөд 2002 оноос 93.2 сая америк доллароор буюу жилд дунджаар 24 орчим хувиар өссөн. 2021 онд өмнөх оноос 46.4 хувь буюу 30.9 сая америк доллароор өссөн нь хамгийн өндөр үнийн дүнгийн өсөлттэй жил болсон байна.

Ургамлын гаралтай бараа, бүтээгдэхүүний экспортын хэмжээ үнийн дүнгээр 2014-2017 онуудад хамгийн өндөр өсөлттэй байж, 2017 онд оргил үедээ буюу 67.6 сая америк долларт хүрч, уул уурхайн бус экспортын 10 хувийг бүрдүүлж байжээ. Энэ төрлийн бүтээгдэхүүний экспорт 2020 оноос 8.1 дахин өссөн дүнтэй байгаа бөгөөд 2021 онд 89.3 сая америк доллар болж, уул уурхайн бус экспортын 12.7 хувийг эзэлж байна.

Хүнсний бэлэн бүтээгдэхүүний экспортын хэмжээ үнийн дүнгээр 2018 онд хамгийн өндөр түвшин буюу 91.4 сая америк долларт хүрч, уул уурхайн бус экспортын 11.5 хувийг эзэлж байжээ. Харин 2019 оноос экспортын дүн буурч, 2021 онд 47.1 сая америк долларын экспорт хийж, уул уурхайн бус экспортын 6.7 хувийг эзэлж байна.

Мал аж ахуйн салбар нь Монгол Улсын эдийн засгийн үндсэн салбар бөгөөд экспортын бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэх өргөн нөөц боломжтой салбар юм. Мал аж ахуйн гаралтай бараа бүтээгдэхүүний экспорт 2002 оноос жилд дунджаар 9.7 хувиар буюу нийт 13.4 сая америк доллароор өссөн. МAA-н гаралтай бүтээгдэхүүний экспорт 2018 онд оргил үедээ хүрч, 102.1 сая америк долларын экспорт хийж байсан бол 2021 онд 42.3 сая америк долларын бараа, бүтээгдэхүүн экспортолж, уул уурхайн бус экспортын үнийн дүнгийн 6.0 хувийг бүрдүүлж байна.


Түүхий болон боловсруулсан арьс шир, түүгээр хийсэн бүтээгдэхүүн нь 2000-аад онд манай улсын экспортын гол бүтээгдэхүүн байж, уул уурхайн бус экспортын 20 орчим хувийг эзэлдэг байсан бол 2021 онд 6.4 сая америк долларын экспорт хийж, уул уурхайн бус экспортын 0.91 хувийг эзэлж байна.



## Уул уурхайн бараа, бүтээгдэхүүний экспорт

2002 онд уул уурхайн бараа бүтээгдэхүүний экспорт үнийн дүнгээр 292.7 сая америк доллар байсан бол 2002-2021 оны хооронд жилд дунджаар 22.7 хувиар өсөж, 2021 онд хамгийн өндөр дүнтэй буюу 8.5 тэрбум америк долларт хүрч, 2002 оноос 29-дахин өссөн байна (Зураг 5).

Зураг 5. Уул уурхайн бараа, бүтээгдэхүүний экспорт, барааны бүлэг, мян.америк. доллароор, 2002-2021 он



2002 онд зэсийн баяжмал уул уурхайн салбарын экспортын 80 орчим хувийг эзэлж үнийн дүнгээр 140 сая америк доллар байсан бол 2002 оноос жилд дунджаар 25 хувиар өсөж, 2021 онд 2.9 тэрбум америк долларт хүрч, уул уурхайн салбарын экспортын 34.0 хувийг эзэлж байна.

Чулуун нүүрсний экспорт 2009 оноос эхлэн эрчимтэй өсөж, үнийн дүнгээр жилд дунджаар 40 орчим хувиар өсөж, 2021 онд 2.7 тэрбум америк доллар болж, уул уурхайн гаралтай бараа бүтээгдэхүүний экспортын 32.3 хувийг бүрдүүлж байна. 2019 онд чулуун нүүрсний экспорт дээд цэгтээ хүрч, 3.07 тэрбум америк долларын экспорт хийсэн нь уул уурхайн салбарын экспортын 45.2 хувийг бүрдүүлж байв.

Боловсруулаагүй, хагас боловсруулсан алт үнийн дүнгээр 2020 онд хамгийн өндөр буюу 1.79 тэрбум америк долларын экспорт хийж, уул уурхайн экспортын 25.4 хувийг бүрдүүлсэн бол 2021 онд нэг тэрбум америк долларын бараа бүтээгдэхүүн экспортолжээ.


Төмрийн хүдэр, баяжмалын экспорт 2009 оноос эрчимжиж эхэлсэн бөгөөд үнийн дүнгээр жилд дунджаар 30 орчим хувиар өссөн байна. 2021 онд төмрийн хүдэр, баяжмалын экспорт өмнөх оноос 48.8 хувиар өсөж, 952.2 сая америк долларт хүрч, уул уурхайн салбарын экспортын 11.1 хувийг эзэлсэн байна.

## 1.2. Экспортын түнш орнууд

2021 онд Монгол Улс дэлхийн нийт 159 улстай худалдаа хийснээс 64 оронд нийт 211 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүн<sup>4</sup> экспортолсон байна. Үнийн дүнгээр экспортын голлох түнш улсуудыг дурдвал нийт экспортын 82.7 хувийг БНХАУ-д, 9.4 хувийг Швейцар улсад, 2.7 хувийг Сингапур улсад, 2.4 хувийг БНСУ-д экспорт хийсэн бөгөөд эдгээр нь манай улсын нийт экспортын 97.2 хувийг эзэлж байна.

Монгол Улсаас бараа, бүтээгдэхүүн экспортолдог улс орнуудыг БТКУС-ийн 8 оронгийн түвшинд бараа, бүтээгдэхүүний гол нэр төрлийн тоогоор эрэмбэлэхэд 2021 онд Монгол Улс хамгийн олон буюу 55 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүнийг БНХАУ-д экспортолсон бол АНУ-д 27, ХБНГУ-д 26, ОХУ-д 25 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүн экспортолсон байна (Зураг 6).

Зураг 6. Монгол Улсын экспортын түнш орнууд, экспортоор гаргасан гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний нэр төрлийн тоогоор, 2021 он




Эх сурвалж: ГЕГ-ийн 2021 оны статистик мэдээлэлд тулгуурлан хийсэн судлаачийн тооцоолол

2021 онд хамгийн өндөр үнийн дүнтэй экспортоор гарсан болон олон орнууд руу экспортоор гарсан зарим гол нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг сонгон авч шинжилгээ хийхэд бараа, бүтээгдэхүүний нэгжийн үнэ нь экспортоор гардаг улсын тоо, Монгол Улсын хилээс эцсийн экспортлогч хүртэлх зайтай эерэг хамааралтай байдаг байна. Тодруулбал, экспортын бараа, бүтээгдэхүүн нь боловсруулалт хийгдэж, бэлэн бүтээгдэхүүн болсон байх тусмаа илүү хол зайд, олон орнууд руу, өндөр үнээр экспортлогддог байна (Зураг 7).

4 БТКУС -ийн 4 оронгийн түвшинд барааны нэр төрлийг ангилсан



Зураг 7. Зарим гол нэрийн бараа, бүтээгдэхүүний нэгжийн үнэ ба экспортолсон улсын тооны хамаарал



Монгол Улсаас хамгийн олон оронд экспортоор гардаг бараа, бүтээгдэхүүн нь эмэгтэйчүүдийн (охидын) сүлжмэл кофт, цамц, блузк бөгөөд 31 оронд экспортлогдсон байна. Түүнчлэн хамгийн олон оронд буюу 27-29 оронд экспортоор гардаг свитер, пуловер, джемпер, жилет болон бусад сүлжмэл гадуур цамц, ямааны ноолууран сүлжмэл свитер, джемпер, ямааны ноолууран эмэгтэй өмд зэрэг бараа, бүтээгдэхүүнүүд байдаг байна. Зөвхөн нэг улс руу экспортлогддог бараа, бүтээгдэхүүнүүд нь ихэвчлэн хагас боловсруулалт хийгдсэн эсвэл боловсруулаагүй түүхий эд<sup>5</sup> байгаа бөгөөд нэгжийн үнэ нь дунджаар 3 америк доллар байна. Харин 20-с дээш оронд экспортоор гардаг бараа, бүтээгдэхүүний нэгжийн үнэ нь дунджаар 56 орчим америк доллар байгаа нь зөвхөн нэг улс руу экспортоор гардаг бараа, бүтээгдэхүүнээс 17 дахин өндөр дүнтэй байна.

5 Боловсруулаагүй нефть, амьд адуу, бөөрөнхий мод зэрэг зарим хэмжих нэгжийн хувьд ялгаатай бараа бүтээгдэхүүнийг дундаж нэгжийн үнэ тооцохдоо хасч тооцсон болно.

## II. МОНГОЛ УЛСЫН ЭКСПОРТЛОГЧ АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

### 2.1. Монгол Улсын экспортлогч аж ахуйн нэгжийн ерөнхий үзүүлэлт

Энэхүү бүлгийг Үндэсний статистикийн хорооноос 5 жил тутам зохион байгуулан явуулдаг 7 дахь удаагийн буюу аж ахуйн нэгжийн 2021 оны тооллогын үр дүнд үндэслэн боловсрууллаа.

Аж ахуйн нэгжийн 2021 оны тооллогод 151.6 мянган аж ахуйн нэгж хамрагдсанаас 30 орчим хувь нь ба 46 мянган аж ахуйн нэгж сүүлийн 2 жилд (2020-2021 онуудад) тасралтгүй үйл ажиллагаа явуулсан байна. 2020 онд 41.6 мянган аж ахуйн нэгж, 2021 онд 55.1 мянган аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна.

2020-2021 онуудад үйл ажиллагаа тасралтгүй явуулсан аж ахуйн нэгжийн 4.2 хувь нь буюу 1,923 аж ахуйн нэгж экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргасан бөгөөд тэдгээрийн 1219 (2.6%) нь заримдаа, 704 (1.5%) нь тогтмол экспорт хийж байна.

### Байршлаар

Экспортод бүтээгдэхүүн үйлчилгээ гаргаж буй аж ахуйн нэгжүүдийн 77.1% буюу 1.5 мянга орчим аж ахуйн нэгж Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг байна. Түүнчлэн Өмнөговь (60 аж ахуйн нэгж), Дархан-Уул (50 аж ахуйн нэгж), Баян-Өлгий (33 аж ахуйн нэгж), Орхон (32 аж ахуйн нэгж), Ховд (30 аж ахуйн нэгж) зэрэг аймгуудад хамгийн олон экспортлогч аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа явуулж байна (Зураг 8).

Зураг 8. Экспортод бүтээгдэхүүн үйлчилгээ гаргасан аж ахуйн нэгжийн тоо, байршлаар








## Салбараар

Экспортлогч аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн салбараар нь ангилан авч үзвэл боловсруулах үйлдвэрлэлийн салбарт хамгийн олон ба 409 аж ахуйн нэгж заримдаа болон тогтмол давтамжтай экспорт хийсэн байна. Үүний дараа бөөний худалдаа (323), жижиглэн худалдаа (234), тээвэр агуулах (219), шинжлэх ухаан (141), уул уурхай (99) гэсэн салбаруудад хамгийн олон экспортлогч аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа явуулж байна (Зураг 9).


Зураг 9. Экспортын бүтээгдэхүүн үйлчилгээ гаргасан аж ахуйн нэгжийн тоо, салбараар



## Борлуулалтын орлогын түвшин

Экспортлогч аж ахуйн нэгжүүдийн 55.5 хувь нь 300 сая төгрөгөөс бага борлуулалтын орлоготой бичил аж ахуйн нэгж байгаа бол 25.6 хувь нь 301 сая төг- 2.4 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүд байна. Харин 18.9 хувь нь 2.5 тэрбум төгрөгөөс дээш борлуулалтын орлоготой томоохон аж ахуйн нэгжүүд байна (Зураг 10).


Зураг 10. Экспортлогч аж ахуйн нэгж, борлуулалтын орлогын түвшингээр, хувиар, 2020 он



### Ажиллагчдын тооны бүлгээр

Экспортлогч аж ахуйн нэгжүүдийн 62.4 хувь нь 1-9 ажилтантай, 24.1 хувь нь 10-49 ажилтантай бол 13.5 хувь нь 50 ба түүнээс дээш ажилтантай байна (Зураг 11).


Зураг 11. Экспортлогч аж ахуйн нэгж, ажиллагчдын тооны бүлгээр, хувиар, 2020 он



### Хөрөнгө оруулалтын хэлбэрээр

Идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн 4 орчим хувь нь гадаадын хөрөнгө оруулалттай бол экспортлогч аж ахуйн нэгжүүдийн 15.7 хувь нь ба 264 гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд байна. Экспортод бүтээгдэхүүн үйлчилгээ гаргадаг гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн 18.2 хувь нь тээвэр, агуулах салбарт, 17.4 хувь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 17.0 хувь нь бөөний худалдааны салбарт, 15.2 хувь нь уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байна (Зураг 13)

Зураг 12. Экспортлогч аж ахуйн нэгж, хөрөнгө оруулалтын хэлбэрээр, 2020 он



Зураг 13. Гадаадын хөрөнгө оруулалттай экспортлогч аж ахуйн нэгж, эдийн засгийн салбараар, 2020 он





## **Олон улсын стандарт нэвтрүүлсэн байдал**

Нийт аж ахуйн нэгжүүдийн 1.5% нь ISO стандарт нэвтрүүлсэн байна. Харин эдгээрээс экспортод бүтээгдэхүүн үйлчилгээ гаргадаггүй аж ахуйн нэгжүүдийн 1.3% нь л ямар нэг стандарт хэрэгжүүлсэн байгаа бол экспортод бүтээгдэхүүн үйлчилгээ гаргадаг аж ахуйн нэгжүүдийн 5.7% нь бүтээгдэхүүн үйлчилгээндээ олон улсын ISO стандарт нэвтрүүлсэн байна. Иймд экспорт хийдэг аж ахуйн нэгжүүдийн хувьд олон улсын стандарт нэвтрүүлсэн байдал нь бусад аж ахуйн нэгжүүдээс илүү өндөр байна.

## 2.2. Санхүүгийн нөхцөл байдал

МҮХАҮТ, МУИС-ийн Бизнесийн сургуультай хамтран хийсэн “Монголын бизнесийн орчин судалгаа”-ны үр дүнгээр экспортлогч аж ахуйн нэгжүүдэд тулгамдаж буй хамгийн гол хүндрэл бэрхшээлээр гадаад худалдааны санхүүжилтийг нэрлэсэн байдаг. Мөн МҮХАҮТ-ын экспортын санхүүжилттэй холбоотой судалгаагаар экспортлогч аж ахуйн нэгжүүдэд зорилтот санхүүжилтийг шийдэж өгснөөр дунджаар 50-80 хувиар экспортын бараа, бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх боломжтой гэж аж ахуйн нэгжүүд хариулсан. Иймд экспортлогч аж ахуйн нэгжүүдэд тулгарч буй гол бэрхшээлүүдийн нэг нь санхүүжилттэй холбогддог бөгөөд аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн нөхцөл байдлыг энэхүү хэсэгт нарийвчлан авч үзэхийг зорьсон болно.

### Экспортын санхүүжилтийн эх үүсвэр

Идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй экспортлогч аж ахуйн нэгжүүдийн 90 орчим хувь нь өөрийн хөрөнгөөр, 13 хувь нь дотоодын банк, санхүүгийн байгууллагын зээлээр, дөнгөж 2.6 хувь нь Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр санхүүгийн эх үүсвэрээ бүрдүүлж байна. Аж ахуйн нэгжүүд экспорт хийхтэй холбоотой санхүүжилтийн 90 орчим хувийг өөрийн хөрөнгөөр бүрдүүлж байгаа нь энэ төрлийн бизнес эрхлэгчдэд тохирсон зорилтот санхүүжилт дутмаг, санхүүгийн хэрэгцээ өндөр, дэмжлэг шаардлагатай байгааг харуулж байна (Зураг 14).


Зураг 14. Экспортлогч аж ахуйн нэгжийн санхүүжилтийн байдал, санхүүжилтийн эх үүсвэрээр, 2020 он



Экспортлогч аж ахуйн нэгжүүд санхүүжилтээ хэрхэн шийдвэрлэж байгааг эдийн засгийн салбараар авч үзвэл хамгийн олон аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулдаг боловсруулах үйлдвэрийн салбарын аж ахуйн нэгжүүдийн 87 хувь нь өөрийн хөрөнгөөр, 5 хувь нь засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр шийдэж байгаа бол шинжлэх ухааны салбарын аж ахуйн нэгжүүдийн 1 хувь нь олон улсын төсөл хөтөлбөрөөр, бөөний худалдааны салбарын 2 хувь нь гадаадын банк санхүүгийн байгууллагын зээлээр эх үүсвэрийг бүрдүүлсэн байна (Зураг 15).



Зураг 15. Экспортлогч аж ахуйн нэгжийн санхүүжилтийн байдал, санхүүжилтийн эх үүсвэрээр, салбараар, 2020 он



Экспортод бараа, бүтээгдэхүүнээ тогтмол болон заримдаа гаргадаг аж ахуйн нэгжүүдийн экспортын санхүүжилтийн эх үүсвэрээ шийдэж байгаа байдал ерөнхийдөө ойролцоо байгаа боловч тогтмол экспорт хийдэг аж ахуйн нэгжүүд өөрийн хөрөнгөөр болон дотоодын банк санхүүгийн зээлээр шийдэх нь дийлэнх байгаа бол заримдаа экспорт хийж буй аж ахуйн нэгжүүдийн хувьд тогтмол экспортлогчдоос илүү Засгийн газрын хөнгөлөлттэй зээл, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөр шийдэх нь давамгайлж байна (Зураг 16).




Зураг 16. Экспортлогч аж ахуйн нэгж, санхүүжилтийн эх үүсвэр, экспорт хийдэг давтамжаар, хувиар, 2020 он



Аж ахуйн нэгжүүдийн хэмжээгээр авч үзвэл 300 хүртэлх сая төгрөгийн орлоготой бичил экспортлогч аж ахуйн нэгжүүдийн 83.9 хувь нь өөрийн хөрөнгөөр, 300 саяас 2.4 тэрбум төгрөгийн орлоготой жижиг дунд аж ахуйн нэгжүүдийн 74.0-76.5 хувь нь өөрийн хөрөнгөөр, 16 орчим хувь нь дотоодын банк санхүүгийн зээлээр санхүүждэг байна. Харин 2.5 тэрбум төгрөгөөс дээш борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүдийн хувьд 80.1 хувь нь өөрийн хөрөнгөөр, 14.0 хувь нь дотоодын банк, санхүүгийн байгууллагын зээлээр, 2.5 хувь нь гадаадын банк, санхүүгийн байгууллагын зээлээр санхүүждэг гэжээ (Зураг 17).

Зураг 17. Экспортлогч аж ахуйн нэгж, санхүүжилтийн эх үүсвэр, борлуулалтын орлогын бүлгээр, хувиар, 2020 он






## Санхүүгийн гол үзүүлэлтүүд, хандлага

Экспортлогч аж ахуйн нэгжийн санхүүгийн гол үзүүлэлтүүд болох хөрөнгө, авлага, өр төлбөр, мөнгөн хөрөнгийн нөөцийн нөхцөл байдал ямар байгааг энэ хэсэгт авч үзлээ. Экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээ тогтмол гаргадаг аж ахуйн нэгжүүдийн 2021 оны эхний 9 сарын хөрөнгийн нөхцөл байдлыг 2020 оны мөн үетэй харьцуулахад 44.8 хувь нь хэвийн, 26.3 хувь нь буурсан гэсэн. Мөн аж ахуйн нэгжийн 34.7 хувь нь авлагагүй, 37.9 хувь нь авлага нэмэгдсэн гэж хариулсан байна. Түүнчлэн аж ахуйн нэгжүүдийн 24.5 хувь нь өр төлбөр нэмэгдсэн, 54.5 хувь нь өр төлбөргүй байна (Зураг 18).

Хөрөнгийн хэмжээ багасах нь аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд сөрөг нөлөөтэй бөгөөд үйлдвэрлэлийн гарцыг багасган, ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалыг багасгадаг. Аж ахуйн нэгжүүдийн өр төлбөр өнгөрсөн оны мөн үеэс 50-62 хувь хүртэл нэмэгдсэн нь үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах хангалттай эргэлтийн хөрөнгө хомстож энэ нь мөнгөн урсгалд сөрөг нөлөө үзүүлж, үйл ажиллагаа нь муудсаныг харуулж байна.


Зураг 18. Экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээ тогтмол гаргадаг аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн байдал, хувиар /2021 оны эхний 9 сарыг 2020 оны эхний 9 сартай харьцуулсан



2020 онд үйл ажиллагаа явуулсан бүтээгдэхүүн, үйлчилгээ экспортод гаргадаггүй аж ахуйн нэгжүүдийн 30.7 хувь нь нэг сар хүртэлх хугацаанд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахад шаардагдах мөнгөн хөрөнгийн нөөцтэй байгаа бол экспортлогч аж ахуйн нэгжүүдийн 26.5 хувь нь нэг хүртэлх сарын, 32.3 хувь нь 1-3 сарын мөнгөн хөрөнгийн нөөцтэй байна (Зураг 19).

Нийт аж ахуйн нэгжүүдийн дөнгөж 27.2 хувь нь хагас жилээс дээш хугацааны мөнгөн хөрөнгийн нөөцтэй байна. Нийт аж ахуйн нэгжүүд дунджаар 60 орчим хувь нь 3 сар хүртэлх хугацаанд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж чадах мөнгөн хөрөнгөтэй байгаа нь дахин санхүүжилт ойрын хугацаанд шаардагдаж, борлуулалт сайжирч чадахгүй бол өр төлбөрийн хэмжээ нь богино хугацаанд нэмэгдэх магадлалтай байна.

Зураг 19. Мөнгөн хөрөнгийн нөөцийн хүрэлцээтэй хугацаа, хувиар, 2020 он




### Экспортлогч аж ахуйн нэгжийн зээлийн хамрагдалт

Нийт аж ахуйн нэгжүүдийн дунджаар 36.3 хувь нь ямар нэг зээлтэй байгаа бол экспорт хийдэг аж ахуйн нэгжүүдийн хувьд улсын дунджаас их буюу 41.3 хувь нь зээлтэй байна (Зураг 20).

Экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээг тогтмол болон заримдаа гаргадаг аж ахуйн нэгжүүд нь экспорт хийдэггүй аж ахуйн нэгжүүдээсээ дунджаар 4-6 нэгж хувиар илүү зээлтэй байгаа нь экспортын зардал өндөр байгааг харуулж байна.

Зураг 20. Зээлтэй аж ахуйн нэгж, экспортлогч эсэх, хувиар, 2020 он




Тогтмол бүтээгдэхүүн, үйлчилгээ экспортолдог зээлтэй аж ахуйн нэгжүүдийн 71.6 хувь нь банк, 20.8 хувь нь хувь хүн, 10.8 хувь нь бусад эх үүсвэрээс зээл авсан байна (Зураг 21).

Аж ахуйн нэгжүүдийн 70-77 хувь нь банкаас, 17-21 хувь нь хувь хүнээс зээл авч байгаа нь Засгийн газрын зүгээс зорилтот дэмжлэг бага, цаашид



дэмжлэг бодлого шаардагдаж байгааг харуулж байна. Түүнчлэн, зээлгүй аж ахуйн нэгжүүдийн хувьд тодорхой хэсэг нь зээлийн хүртээмж муу бөгөөд банкнуудын хэт өндөр хүү, барьцаа хөрөнгө болон бусад шалгуурууд нь зээл авахад хүндрэл үүсгэдэг гэсэн бол экспортлогч аж ахуйн нэгжүүдийн хувьд зээл олгодог байгууллагын хүнд сурталтай холбоотой асуудлыг онцлон дурдсан байна.

Зураг 21. Зээлтэй аж ахуйн нэгж, зээлийн эх үүсвэрээр, хувиар, 2020 он




### 2.3. Хүний нөөц

Экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргадаг аж ахуйн нэгжүүдэд нийт 66.7 мянган хүн ажиллаж байна. Энэ нь нийт аж ахуйн нэгжийн ажиллагчдын 14.3 хувьтай тэнцэж байна. Монгол Улсын аж ахуйн нэгжүүдэд тулгардаг нэг гол бэрхшээл нь мэргэжлийн, тогтвортой ажиллах хүчний дутагдалтай холбоотой асуудлууд байдаг. МҮХАҮТ-ын Монголын бизнесийн орчны судалгааны үр дүнгээр бизнес эрхлэгчдэд ур чадвартай мэргэжлийн ажиллагчид, гадаад худалдааны менежер, дээд түвшний удирдах ажилтан, инженер техникийн ажилтны олдоц хангалтгүй, хомсдолтой байдаг гэж гарсан. Энэ хэсэгт экспортлогч аж ахуйн нэгжүүдийн ажиллах хүчтэй холбоотой шийдвэрлэх шаардлагатай асуудлуудыг тодруулахыг зорилоо.

#### Ажиллагчдын тоо

Монгол Улсад 2020 онд үйл ажиллагаа явуулсан нийт аж ахуйн нэгжийн 82.4 хувь нь 1-9 ажилтантай байгаа бол экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргадаг аж ахуйн нэгжүүдийн 62.4 хувь нь 1-9 ажилтантай байна. Мөн экспортлогч аж ахуйн нэгжүүдийн 12.2 хувь нь 10-19 ажилтантай, 11.9 хувь нь 20-49 ажилтантай, 13.5 хувь нь 50 ба түүнээс дээш ажилтантай байна (Зураг 22).

Зураг 22. Аж ахуйн нэгжийн ажиллагчдын тоо, ажиллагчдын тооны бүлгээр, хувиар, 2020 он




Заримдаа экспорт хийдэг аж ахуйн нэгжүүдийн 67.0 хувь нь 1-9 ажилтантай буюу илүү цөөн тооны ажиллагчтай байгаа бол тогтмол экспорт хийдэг аж ахуйн нэгжүүдийн 20 гаруй хувь нь 50 ба түүнээс дээш буюу илүү олон тооны ажиллагчтай байна (Зураг 23).





Энэ нь бүтээгдэхүүнээ экспортод гаргадаг аж ахуйн нэгж (экспортлогч аж ахуйн нэгжүүдийн 14 хувь нь 50-аас дээш ажилтантай буюу улсын дундаж 3 хувиас 9 нэгж хувиар их)-үүд илүү олон ажлын байр бий болгож байна.

Зураг 23. Экспортлогч аж ахуйн нэгжийн ажиллагчдын тоо, экспорт хийдэг давтамжаар, хувиар, 2020 он




Эдийн засгийн салбаруудын хувьд авч үзвэл тээвэр-агуулах, боловсруулах үйлдвэрлэл, уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй экспортлогч аж ахуйн нэгжүүдийн 50-аас дээш ажилтантай хувь хэмжээ бусад салбаруудтай харьцуулахад өндөр байна.

### Ажиллах хүчний хомсдол, тулгарч буй хүндрэл бэрхшээл

Аж ахуйн нэгжүүдэд хүний нөөцийн дутагдал байгаа эсэхийг тодруулахад экспортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаггүй аж ахуйн нэгжүүдийн хувьд дундаж түвшинд байгаа бол экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргадаг аж ахуйн нэгжүүдийн 24-26 хувь нь хүний нөөцийн дутагдалтай байгаа нь улсын дунджаас өндөр хувьтай байна (Зураг 24).

Зураг 24. Хүний нөөцийн дутагдалтай аж ахуйн нэгж, хувиар, 2020 он



Аж ахуйн нэгжүүд хүний нөөцийн дутагдалтай эсэхийг салбараар тодруулахад зочид буудал, зоогийн газар (31%), боловсруулах үйлдвэрлэл (30%), барилга дэд бүтэц (29%), эрүүл мэнд (28%) -ийн салбарт ажиллах хүч илүү дутагдалтай байна гэж хариулжээ (Зураг 25).

Зураг 25. Хүний нөөцийн дутагдалтай аж ахуйн нэгж, салбараар, хувиар, 2020 он



Нийт аж ахуйн нэгжүүдээс мэргэжлийн ажиллах хүчээ олж чадахгүй байгаа шалтгааныг нь тодруулбал, ажиллагчид тогтвортой ажиллах хүсэлгүй, ажлын ачаалал даах чадваргүй, ажлын туршлага бага, цалин хангалттай өгч чадахгүй байгаа, орон нутагт ажиллах сонирхолгүй зэрэг 5 гол хүчин зүйлийг нэрлэсэн байна. Харин экспортлогч аж ахуйн нэгжүүдийн хувьд улсын дундажтай ойролцоо дүнтэй байгаа боловч ажлын туршлагагүй, гадаад хэлний мэдлэг дутмаг зэргийг онцолсон байна (Зураг 26).



Зураг 26. Хүний нөөцийн дутагдалтай аж ахуйн нэгж, шаардлагатай ажилтнаа олж чадахгүй байгаа шалтгаанаар, хувиар, 2020 он



Заримдаа экспорт хийдэг аж ахуйн нэгжүүдэд ажиллах хүч нь тогтвортой ажиллах хүсэлгүй, ажлын байрны нөхцөл хангалтгүй зэргээс хамааран шаардлагатай ажилтны олдоц бага байдаг бол тогтмол экспортлогч аж ахуйн нэгжүүдийн хувьд ажлын ачаалал даах чадвар, ажлын туршлагагүй байдал зэргийг онцолсон (Зураг 27).


Зураг 27. Хүний нөөцийн дутагдалтай экспортлогч аж ахуйн нэгж, шаардлагатай ажилтнаа олж чадахгүй байгаа шалтгаанаар, экспорт хийдэг давтамжаар, хувиар, 2020 он



### Ажлын байраа хадгалж үлдэх боломжтой хугацаа

Экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргадаг аж ахуйн нэгжүүдийн 28.1 хувь нь 1-ээс дээш жил өөрийн хөрөнгөөр ажлын байраа хадгалах боломжтой гэж хариулсан ба энэ нь улсын дунджаас бага үзүүлэлт юм. Мөн экспортлогчдын 16.5 хувь нь 1 сар хүртэл, 42.2 хувь нь 1-6 сар хүртэлх хугацаанд л ажлын байраа хадгалж үлдэх боломжтой гэжээ (Зураг 28).

Зураг 28. Үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгж, өөрийн нөөцөөр ажлын байраа цаашид хадгалах боломжтой хугацаагаар, хувиар, 2020 он






## 2.4 Инновац, судалгаа хөгжүүлэлт, технологийн хэрэглээ

Дэлхий даяар технологийн хурдацтай өөрчлөлт дунд байгууллагууд дижитал шилжилтүүд хийж байна. Энэхүү хурдацтай хөгжилд тогтвортой байхын тулд ААН-үүд инновацлаг үйл ажиллагаа явуулж цахим технологийн үйлчилгээг нэвтрүүлж, түүнд шаардагдах ажилчдынхаа ур чадварыг хөгжүүлэх хэрэгцээ шаардлага нэмэгдсээр байна. Иймд Монгол Улсын 2021 оны аж ахуйн нэгжийн тооллогын тоо мэдээлэлд тулгуурлан McKinsey компанийн зөвлөсөн дижитал чадамжийн хүрээнд экспортлогч аж ахуйн нэгжүүдийн мэдээллийн технологи, инновац, судалгаа хөгжүүлэлтийн нөхцөл байдал ямар байгааг энэ хэсэгт харьцуулан харуулахыг зорилоо.

### Харилцагчид төвлөрсөн сэтгэлгээ

Энэ нь хүний мэдрэмж, туршлага дээр суурилан хэрэглэгч үйлчлүүлэгчдэдээ чиглэсэн илүү шинэлэг, хэрэгцээт үйлчилгээг нэвтрүүлэхэд чиглэдэг. Монгол Улсын 2020 онд үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжүүдийн 8 орчим хувь нь 2018-2021 онд шинээр эсвэл мэдэгдэхүйц сайжруулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний инновацыг нэвтрүүлсэн байна. Харин экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргадаг аж ахуйн нэгжүүдийн дунджаар 16.5 хувь буюу улсын дунджаас хоёр дахин их хувь нь үйл ажиллагаа, бүтээгдэхүүндээ инновац сайжруулалт хийсэн байна (Зураг 29).

Зураг 29. 2018-2021 онуудад шинээр эсвэл мэдэгдэхүйц сайжруулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний инновац нэвтрүүлсэн үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгж, хувиар



Нэвтрүүлсэн инновацын үйл ажиллагааны төрлөөр нарийвчлан авч үзэхэд экспортлогч аж ахуйн нэгжийн 13.4 хувь нь ажиллагчдыг сургах үйл ажиллагаа, 9.5 хувь нь биет хөрөнгийг худалдаж авах түрээслэхтэй холбоотой үйл ажиллагаа, 7.8 хувь нь программ хангамж, мэдээллийн өгөгдлийн санг хөгжүүлэх үйл ажиллагаа, 6.7 хувь нь маркетинг, брэнд гаргах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна (Зураг 30).




Зураг 30. 2018-2021 онуудад инновацын үйл ажиллагааг хэрэгжүүлсэн үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгж, хувиар



Нийт экспортлогчдын 16.7 хувь нь ажиллагчдыг сургах дадлагажуулах үйл ажиллагааг одоогоор хэрэгжүүлэх үе шатанд явж байгаа бол 16.2 хувь нь судалгаа хөгжүүлэлтийн ажил хийгдэж байгаа, 12.6 хувь нь маркетинг, брэнд гаргах үйл ажиллагаа хийгдэж байгаа, 12.3 хувь нь инженерчлэл, дизайн, бүтээлч бусад үйл ажиллагаа хэрэгжүүлэн ажиллаж байгаа гэжээ. Нийт аж ахуйн нэгжүүдийн хувьд ажиллагчдыг сургах, судалгаа хөгжүүлэлт болон программ хангамж, мэдээллийн өгөгдлийн санг хөгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагаанд одоогоор илүү анхааран ажиллаж байна (Зураг 31).

Зураг 31. Инновацын үйл ажиллагаа хийгдэж байгаа аж ахуйн нэгж, хувиар, 2020 он





## Agile ажиллах зарчим

Agile ажиллах зарчим нь техник технологи, инновацын дэвшилд тулгуурлан боломжит нөөцийн хүрээнд уян хатан арга барилаар бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчдэд хурдан шуурхай, хүндрэл багатайгаар хүргэх бизнесийн чиг хандлага юм. Харин экспортод бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргадаг аж ахуйн нэгжүүдийн хувьд мэдээлэл харилцаа холбооны систем, зохион байгуулалт менежмент, бүтээгдэхүүн болон бизнесийн үйл явцын хөгжүүлэлт зэрэг бизнесийн үйл явцад илүү төвлөрч, бүх үзүүлэлтээр улсын дунджаас өндөр байна (Зураг 32).

Зураг 32. 2018-2021 онуудад бизнесийн үйл явцын инновац нэвтрүүлсэн аж ахуйн нэгж, хувиар



## Дата ашиглах чадвар, аналитик үндэслэл

Бизнес эрхлэгчдийн тулгарч буй шийдэх асуудлууд өдөр ирэх тусам улам төвөгтэй, таамаглах боломжгүй болж байна. Иймд бизнес эрхлэгчдэд шаардагдах бас нэгэн чухал ур чадвар нь судалгаа, шинжилгээ хийж дата мэдээллийг уншиж ойлгох, асуудлыг задлах, өгөгдөлд дүн шинжилгээ хийх, судалгаа шинжилгээний үр дүнд тулгуурлан шийдвэр гаргах хэрэгцээ шаардлага нэмэгдсээр байна. Энэ нь математик загварчлал, хиймэл оюун ухаан, дата удирдах хэрэгслүүд гэх мэт ирээдүйн байгууллагуудад зайлшгүй шаардлагатай чадваруудыг агуулж байна. Энэ чиглэлд аж ахуйн нэгжүүд хэрхэн ажиллаж байгаа тухайд тодруулан авч үзэхэд нийт аж ахуйн нэгжүүдийн дөнгөж 1.9 хувь нь 2018-2021 онуудад судалгаа хөгжүүлэлтийн ажил хийсэн байна. Харин экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргадаг аж ахуйн нэгжүүдийн 5.5 хувь нь судалгаа хөгжүүлэлтийн ажил хийж улсын дунджаас дээгүүр үнэлгээтэй байгаа ч хангалтгүй түвшинд байна (Зураг 33).

Зураг 33. 2018-2021 онуудад судалгаа хөгжүүлэлтийн ажил хийсэн аж ахуйн нэгж, хувиар



2018-2021 онуудад судалгаа хөгжүүлэлтийн ажил хийсэн нийт аж ахуйн нэгжүүдийн 51.1 хувь нь суурь судалгааны төсөл хэрэгжүүлдэг бол экспортод бүтээгдэхүүн үйлчилгээ гаргадаг аж ахуйн нэгжүүдийн 39.1 хувь нь технологи, туршилт зүгшрүүлэлтийн төсөл, 23.9 хувь нь захиалгат төслийн чиглэлээр ажилласан гэжээ (Зураг 34).

Зураг 34 . Судалгаа хөгжүүлэлтийн ажил хийсэн аж ахуйн нэгж, судалгааны төрлөөр, хувиар, 2020 он






## Шинэ үеийн технологи

Аж ахуйн нэгжүүдийн 82.0 хувь нь үйл ажиллагаандаа компьютер, ухаалаг төхөөрөмж ашигладаг бол экспортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийн 86.1 хувь нь ашиглаж байна. Мөн экспортлогч аж ахуйн нэгжүүдийн 18.6 хувь нь өгөгдлийн сантай, 20.8 хувь нь ямар нэг дата сервертэй байна.

Интернэт ашиглалтын талаар тодруулахад экспортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд имэйл авах, явуулах, харилцагч, хэрэглэгчдэдээ үйлчилгээ үзүүлэх, интернэт банкны үйлчилгээ авах зорилгоор интернэт ашигладаг байна (Зураг 35).

Зураг 35. Аж ахуйн нэгжийн интернэт ашиглалтын зорилго, хувиар, 2020 он



## 2.5. Бизнесийн орчны нөхцөл байдал

Азийн хөгжлийн банкнаас гаргасан “Монгол Улсын хэтийн төлөв 2020” судалгаанд Засгийн газар нь бизнес, институтийн орчныг сайжруулах үүднээс татвар, гаалийн бүрдүүлэлт болон хил дамнасан худалдааг хөнгөвчлөхийг зорьж байна. Засгийн газрын зүгээс цаашид авч хэрэгжүүлэх бодлогыг хүнд суртал, төрийн анхан шатны үйлчилгээ авахад гардаг зардал, авлигыг бууруулахад чиглүүлэх ёстой. Мөн экспортыг, ялангуяа эрдэс баялгийн бус салбарыг дэмжих нь эдийн засгийн бодлогын чухал зорилт болох ёстой. Экспортыг нэмэгдүүлэхийн тулд холбогдох институтийн шинэчлэлийг дэмжиж, хууль эрх зүй, зохицуулалтын орчныг боловсронгуй болгож, экспортын батлан даалт, санхүүжилтийн хөтөлбөрийг цаашид хөгжүүлэн **экспортыг хөгжүүлэх стратегийг макро эдийн засгийн ерөнхий бодлогын салшгүй хэсэг болгох** хэрэгтэйг дурдсан байна.

МҮХАҮТ-аас бизнесийн орчныг үнэлэх, шаардагдах дэмжлэг, шийдлийг тодорхойлох зорилготойгоор 2020 онд Монголын бизнесийн орчин судалгааг хийсэн. Тус судалгааны дүнгээр бизнесийн орчны голлох хүчин зүйлсээс дэд бүтэц, технологийн орчин илүү эерэг сайн үнэлгээтэй байсан бол эдийн засгийн орчин, засаглал хууль эрх зүйн орчин хамгийн бага үнэлэгдсэн бөгөөд энэ чиглэлд бизнесийн орчныг сайжруулахад анхаарч ажиллах шаардлагатай гэсэн үр дүн гарсан. Энэхүү хэсэгт экспортлогч аж ахуйн нэгжүүдийн бизнесийн орчныг сайжруулахад шаардагдах дэмжлэгийн талаар тодруулан авч үзэв.






## Төрийн байгууллагын дэмжлэг


Бизнесийг хөгжүүлэхэд төрийн бодлогын түвшинд нэн тэргүүнд авбал зохистой арга хэмжээг тодруулахад нийт аж ахуйн нэгжийн 29.4 хувь нь авлига, хүнд суртлыг бууруулах, 23.7 хувь нь зээлийн хүүг бууруулах, 15.0 хувь нь НДШ-ийн иргэдийн хувь хэмжээг бууруулах шаардлагатай гэжээ. Харин экспортлогч аж ахуйн нэгжүүдийн 32.7 хувь нь авлига, хүнд суртлыг бууруулах шаардлагатай гэсэн нь улсын дунджаас өндөр хувьтай байна (Зураг 36).

Зураг 36. Аж ахуйн нэгжийн бизнесийг хөгжүүлэхэд төрийн бодлогын түвшинд нэн тэргүүнд хэрэгжүүлэх арга хэмжээ, хувиар, 2020 он



Экспорт хийдэг давтамж хамаарахгүйгээр бүх аж ахуйн нэгжүүд авлига, хүнд суртлыг бууруулах шаардлагатай байна гэсэн бол тогтмол экспорт хийдэг аж ахуйн нэгжүүд албан зөвшөөрлийн хураамжийн хэмжээг бууруулах, дэд бүтцийг сайжруулахад анхаарал хандуулах хэрэгтэй гэж үзсэн. Харин заримдаа экспорт хийдэг аж ахуйн нэгжүүд зээлийн хүүг бууруулах, НДШ-ийн иргэдээс авах хувь хэмжээг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь зохистой гэжээ. (Зураг 37).


Зураг 37. Экспортлогч аж ахуйн нэгжийн бизнесийг хөгжүүлэхэд төрийн бодлогын түвшинд нэн тэргүүнд хэрэгжүүлэх арга хэмжээ, экспорт хийдэг давтамжаар, хувиар, 2020 он



### Үйл ажиллагаанд төрийн байгууллагаас шаарддаг баримт бичиг

2020 онд үйл ажиллагаа явуулсан нийт аж ахуйн нэгжийн 44.3 хувь нь үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахдаа төрийн байгууллагаас ямар нэг баримт, бичиг тодорхойлолт шаарддаг гэсэн бол тогтмол экспорт хийдэг аж ахуйн нэгжүүдийн 46.6 хувь нь ямар нэг баримт бичиг тодорхойлолт шаарддаг гэсэн ба энэ нь улсын дунджаас өндөр байна (Зураг 38).


Зураг 38. Аж ахуйн нэгж, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад төрийн байгууллагаас баримт бичиг, тодорхойлолт шаарддаг байдал, экспорт хийдэг давтамжаар, хувиар, 2020 он





Экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргадаг нэг аж ахуйн нэгж дунджаар 29 орчим баримт бичиг, тодорхойлолт бүрдүүлж, төрийн байгууллагад өгч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах шаардлагатай байдаг байна. Экспортын бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргадаг аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авахдаа дунджаар 13 бичиг, гэрээ хийх дүгнэлт гаргуулахад тус бүр 3 бичиг, батламж авахад 2 бичиг, үнэлгээ гаргуулах бусад үйлчилгээ авахад тус бүр 4 төрлийн баримт бичиг, тодорхойлолт бүрдүүлж, төрийн байгууллагад өгдөг байна (Зураг 39).

Зураг 39. Экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргадаг аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа явуулахад төрийн байгууллагад бүрдүүлж өгсөн баримт бичиг, тодорхойлолтын дундаж тоо, 2020 он



## Экспортлогч аж ахуйн нэгжүүдийн нөхцөл байдлын дүгнэлт

2021 оны аж ахуйн нэгжийн тооллогод хамрагдсан аж ахуйн нэгжийн 30 орчим хувь нь цар тахлын хязгаарлалт хийгдсэн жилүүд буюу 2020-2021 онуудад үйл ажиллагаа тасралтгүй явуулсан байна. Нийт аж ахуйн нэгжийн 4.2 хувь буюу 1923 аж ахуйн нэгж экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргадаг байна. Эдгээр экспортлогч аж ахуйн нэгжүүдийн 81 орчим хувь нь 2.5 тэрбум төгрөгөөс бага борлуулалтын орлоготой бичил, жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид байгаа ба нийт 66.7 мянган хүн ажиллаж байгаа нь нийт аж ахуйн нэгжид ажиллагчдын 14.3 хувийг ажлын байраар хангаж байна.

### Санхүүгийн нөхцөл байдлын хувьд:

- Экспортлогч аж ахуйн нэгжүүдийн дунджаар 90 орчим хувь нь экспорт хийхтэй холбоотой санхүүжилтийн эх үүсвэрийг өөрийн хөрөнгөөр шийдвэрлэж байгаа нь энэ төрлийн бизнес эрхлэгчдэд тохирсон зорилтот санхүүжилтийн дэмжлэг дутмаг, санхүүгийн хэрэгцээ өндөр байгаа бөгөөд хангалттай өсөн дэвжиж чадахгүй байгааг харуулж байна. Өөрийн хөрөнгөөс гадна тогтмол экспорт хийдэг аж ахуйн нэгжүүд дотоодын банк, санхүүгийн байгууллагын зээлээр санхүүжилтээ шийдэж байхад заримдаа экспорт хийдэг аж ахуйн нэгжүүдийн хувьд Засгийн газрын хөнгөлөлттэй зээл, олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрөөр шийдэх нь илүү байна.
- 2021 оны эхний 9 сарын санхүүгийн гол үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад экспортлогч аж ахуйн нэгжүүдийн 26.3 хувь нь хөрөнгийн хэмжээ буурсан, 34.7 хувь нь авлага нэмэгдсэн, 54.5 хувь нь өр төлбөр нэмэгдсэн гэжээ. Аж ахуйн нэгжүүдийн өр төлбөр өссөн нь үйл ажиллагаа явуулахад шаардагдах хангалттай эргэлтийн хөрөнгө хомстож, мөнгөн урсгалд сөрөг нөлөө үзүүлэн, үйл ажиллагаа нь муудсаныг харуулж байна. Мөн экспортлогч болон нийт аж ахуйн нэгжүүдийн 60 орчим хувь нь 3 сар хүртэлх хугацаанд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж чадах мөнгөн хөрөнгөтэй байгаа нь борлуулалт хангалттай өсөлтгүй үед санхүүжилт ойрын хугацаанд шаардагдаж, өр төлбөрийн хэмжээ нь нэмэгдэх магадлалтай байна.
- Экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргадаг аж ахуйн нэгжүүдийн 41.3 хувь нь зээлтэй байна. Энэ нь экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргадаггүй аж ахуйн нэгжүүдээс дунджаар 4-6 хувиар өндөр байгаа нь экспорт хийх зардал өндөр байгааг харуулж байна. Экспортлогч аж ахуйн нэгжүүдийн зээлийн эх үүсвэрийн 70-77 хувийг банкнаас, 17-21 хувийг хувь хүнээс авсан зээл бүрдүүлж байгаа нь Засгийн газрын зүгээс зорилтот дэмжлэг шаардагдаж байгааг харуулж байна.

### Хүний нөөцийн нөхцөл байдлын хувьд:

- Экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргадаг аж ахуйн нэгжүүдийн 24-26 хувь нь хүний нөөцийн дутагдалтай байгаа нь улсын дунджаас өндөр дүн юм. Эдгээр аж ахуйн нэгжүүд ажлын туршлагагүй, гадаад хэлний мэдлэг дутмаг зэрэг шалтгаанаар мэргэжлийн ажиллах хүчээ олж чадахгүй байна. Өөрийн нөөцөөр нийт экспортлогч аж ахуйн нэгжүүдийн 58.7 хувь нь хагас жилээс бага хугацаанд ажлын байраа хадгалж үлдэх боломжтой гэжээ.



### **Инновац, судалгаа хөгжүүлэлт, технологийн нөхцөл байдлын хувьд:**

- McKinsey компанийн зөвлөсөн дижитал чадамжийн хүрээнд экспортлогч аж ахуйн нэгжүүдийн мэдээлэл технологи, инновац, судалгаа хөгжүүлэлтийн ажлын нөхцөл байдал ямар байгааг харьцуулж үзэхэд хэрэглэгч, үйлчлүүлэгчдэдээ чиглэсэн бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг экспортлогч аж ахуйн нэгжүүдийн 16.5 хувь нь л хийсэн бол 29.5 хувь нь бүтээгдэхүүн, үйлчилгээг хүндрэл бэрхшээл багатай хэрэглэгчдэд хүргэх зорилгоор бизнесийн үйл явцдаа инновац нэвтрүүлсэн байна. Харин 5.5 хувь нь судалгаа хөгжүүлэлтийн ажил хийсэн бол 86.1 хувь нь үйл ажиллагаандаа компьютер, ухаалаг төхөөрөмж ашиглаж, бараа бүтээгдэхүүнээ онлайнаар хүргэх, мэдээ, мэдээлэл авах, интернэт банкны үйлчилгээ авах зорилгоор интернэт ашигладаг байна.

### **Бизнесийн орчны нөхцөл байдлын хувьд:**

- Экспортлогч аж ахуйн нэгжүүдэд бизнесийг хөгжүүлэхэд төрийн бодлогын түвшинд нэн тэргүүнд авлига, хүнд суртлыг бууруулах шаардлагатай байна. Мөн банк, санхүүгийн байгууллагын зээлийн хүүг бууруулах, НДШ-ийн иргэдээс авах хувь хэмжээг бууруулах, албан зөвшөөрлийн хураамжийн хэмжээг бууруулах, экспорт, импортын бараа бүтээгдэхүүнийг гаалийн хөнгөлөлттэй нөхцөлөөр нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэх хэрэгтэй гэжээ.
- Экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргадаг нэг аж ахуйн нэгж дунджаар 29 орчим баримт бичиг, тодорхойлолт бүрдүүлж үйл ажиллагаагаа тасралтгүй явуулдаг.



## ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Монгол Улсын экспортын салбар сүүлийн 26 жилийн хугацаанд жилд дунджаар 14.5 хувиар өсөж, 2021 онд 9.2 тэрбум америк долларт хүрч, үнийн дүнгээр ДНБ-ий 60.5 хувьтай тэнцэж байна. Монгол Улсад экспортын бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргадаг 1923 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж нийт ажиллагчдын 14.3 хувийг ажиллуулж байна.

Экспортын бараа бүтээгдэхүүний 7.6 хувийг уул уурхайн бус бараа бүтээгдэхүүн, 92.4 хувийг уул уурхайн түүхий эд эзэлж нийт экспортын бараа бүтээгдэхүүний нэр төрлийн<sup>6</sup> 90 орчим хувийг 1-5 улс оронд экспортолж байна. Экспортын бараа бүтээгдэхүүнд түүхий эд давамгайлж байгаа нь манай улсын эдийн засгийг гадаад зах зээлээс хамааралтай, гадаад шокт өртөмтгий эмзэг бүтэцтэй болгож байна.

Зорилтот санхүүжилтийг шийдэж өгснөөр экспортлогчид дунджаар 50-80 хувиар экспортын бараа бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх боломжтой<sup>7</sup> ч экспортлогч аж ахуйн нэгжүүдийн 90 орчим хувь нь өөрийн хөрөнгөөр<sup>8</sup> шаардагдах экспортын санхүүжилтийг бүрдүүлж байна. Цаашилбал 2.6 хувь нь Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр санхүүжилтийн эх үүсвэрээ бүрдүүлж байгаа бөгөөд үүний 81 хувь нь 1-19 ажилчидтай байгаа нь Засгийн газрын зээл бичил, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд илүү хүртээмжтэй байдаг. Мөн экспорт хийдэг аж ахуйн нэгжүүдийн зээлийн эх үүсвэр нь дотоодын банк, хувь хүмүүсээс бүрдэж байгаа нь экспорт хийх үйл ажиллагаа зардал өндөртэй байдаг гэж дүгнэлт хийж болохоор байна.

Экспортлогч дөрвөн аж ахуйн нэгж тутмын нэг нь ажлын туршлагагүй, гадаад хэлний мэдлэг дутмаг зэрэг шалтгаанаар мэргэжлийн ажиллах хүчээ олж чаддаггүй байна. McKinsey компанийн зөвлөсөн дижитал чадамжийн хүрээнд экспортлогч аж ахуйн нэгжүүдийн мэдээлэл технологи, инновац, судалгаа хөгжүүлэлтийн ажлын нөхцөл байдлыг судалж үзэхэд сүүлийн 4 жилийн хугацаанд экспортлогч аж ахуйн нэгжүүдийн 16.5 хувь (улсын дүнгээс 2 дахин өндөр) нь хэрэглэгч, үйлчлүүлэгчдэдээ чиглэсэн бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг хийсэн бол 29.5 хувь нь бизнесийн үйл явцдаа инновац нэвтрүүлсэн, 86.1 хувь нь үйл ажиллагаандаа компьютер, ухаалаг төхөөрөмж ашиглаж, 18.6 хувь нь өгөгдлийн сантай, 20.8 хувь нь дата сервертэй үйл ажиллагаа явуулж байгаа нь өгөгдлийн шинжилгээнд суурилсан хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг тодорхойлж, бүтээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх урьдач нөхцөл бүрдэж байна гэж үзэж байна. Түүнчлэн судалгаанаас гарсан нэг анхаарал татсан үр дүн нь экспортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийн дөнгөж 5.5 хувь нь 2018-2021 онуудад судалгаа хөгжүүлэлтийн ажил хийсэн. Экспортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд түнш орнуудын зах зээлийн судалгаа шинжилгээ хийж, тухайн зорилтот хэрэглэгчид тохирсон бүтээгдэхүүн хөгжүүлэлт хийх нь маш чухал байдаг. Гэвч Монгол Улсын экспортлогч аж ахуйн нэгжүүдийн 95 орчим хувь нь ямар нэг төрлийн судалгаа хөгжүүлэлт хийгээгүй байгаа нь эдгээр аж ахуйн нэгжүүдэд энэ төрлийн үйл ажиллагаанд зарцуулах хангалттай

6 БТКУС-ын 4 орны түвшинд бараа бүтээгдэхүүний нэр төрлийг ангилан авч үзсэн.

7 Монгол Улсын жижиг дунд үйлдвэрлэлүүдийн экспортын санхүүжилтийн судалгаа, МҮХАҮТ, Европ Монголын хамтарсан худалдааны танхим, ЕХ-ны худалдааг дэмжих төсөл

8 Давхардсан санхүүгийн эх үүсвэрээр



санхүүгийн эх үүсвэр дутмаг эсвэл мэргэжлийн ажиллах хүч хомстолтой гэж дүгнэж болохоор байна. Иймд экспортлогч аж ахуйн нэгжүүдэд онцгойлон судалгаа, хөгжүүлэлтийн ажлыг дэмжих санхүүжилт, хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр хангах, ажиллах хүчийг чадавхжуулах, зөвлөгөө мэдээлэл өгөх хэрэгцээ шаардлагатай байгаа ба энэ нь аж ахуйн нэгжүүдийн экспортын зардлыг бууруулж, бизнесээ илүү бодитой төлөвлөн экспортын гарцаа нэмэгдүүлэхэд дэмжлэг болох ач холбогдолтой.

МҮХАҮТ, МУИС хамтран хийсэн 2020 оны Монголын бизнесийн орчны судалгаагаар бизнес эрхлэгчид бизнесийн орчны голлох хүчин зүйлсээс дэд бүтэц, технологийн орчинд илүү эерэг сайн үнэлгээ өгсөн бол эдийн засгийн орчин, засаглал хууль эрх зүйн орчныг хамгийн бага оноогоор үнэлсэн. Иймд энэ чиглэлд бизнесийн орчныг сайжруулахад анхаарч ажиллах шаардлагатай гэсэн үр дүн гарсан. Харин аж ахуйн нэгжийн 2021 оны тооллогод хамрагдсан **идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа экспортлогч аж ахуйн нэгжүүд бизнесийг хөгжүүлэхэд төрийн бодлогын түвшинд нэн тэргүүнд авлига, хүнд суртлыг бууруулах шаардлагатай байгааг онцолсон** юм. Мөн банк, санхүүгийн байгууллагын зээлийн хүүг бууруулах, НДШ-ийн иргэдээс авах хувь хэмжээг бууруулах, албан зөвшөөрлийн хураамжийн хэмжээг бууруулах, экспорт, импортын бараа бүтээгдэхүүнийг гаалийн хөнгөлөлттэй нөхцөлөөр нэвтрэх боломжийг бүрдүүлэх хэрэгтэй байна гэжээ.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Аж ахуйн нэгжийн 2021 оны улсын тооллогын нэгдсэн дүн, Үндэсний статистикийн хороо
- Аж ахуйн нэгжийн 2016 оны улсын тооллого нэгдсэн дүн, Үндэсний статистикийн хороо
- Монголын бизнесийн орчны судалгаа-2020, МҮХАҮТ, МУИС-ийн Бизнесийн сургууль
- Монгол Улсын жижиг дунд үйлдвэрлэлүүдийн экспортын санхүүжилтийн судалгаа, МҮХАҮТ, Европ Монголын хамтарсан худалдааны танхим, ЕХ-ны Худалдааг дэмжих төсөл
- Аж үйлдвэрийн салбар-2020, Үндэсний статистикийн хороо
- Монгол Улс: Цогц дүн шинжилгээ, Дэлхийн банк групп
- Mongolia's Economic Prospects: Resource-Rich and Landlocked between Two Giants, Asian Development Bank
- Six capabilities to sustain digital transformations, McKinsey&Company
- Mapping China's exports, Stockholm International Peace Research Institute
- Governance and Export Performance in Vietnam, Son Thanh Nguyen and Yanrui Wu (Journal of Southeast Asian Economies Vol. 37, No. 1 (2020), pp. 1–25)
- Relationship between Exports, Economic Growth and Other Economic Activities in India: Evidence from VAR Model, Mohammad SUBHAN, Majed ALHARTHI, Md Shabbir ALAM, Prabha THOUDAM, Khaliquzzaman KHAN5, 2021
- [www.1212.mn](http://www.1212.mn) веб хуудас, Үндэсний статистикийн хороо
- <https://gaali.mn/> веб хуудас, Гаалийн ерөнхий газар
- [www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn) веб хуудас, Монголбанк
- <https://www.trademap.org/Index.aspx> веб хуудас, Олон улсын худалдааны төв





A series of horizontal dotted lines for writing, spanning the width of the page.





## **МҮХАҮТ–ын Судалгааны Институт**

МҮХАҮТ–ын байр, М.Гандигийн гудамж,  
15–р хороо, Хан–Уул дүүрэг,  
Улаанбаатар хот 17011, UB Post – 1010011001  
Утас: (+976) 77277070, Факс: (+976) 11324620

 [www.mongolchamber.mn](http://www.mongolchamber.mn)

 [research@mongolchamber.mn](mailto:research@mongolchamber.mn)